

БАТЛАВ:
 ӨЛЗИЙТ СУМЫН ГХУССЗ-ИЙН
 ДАРГА Х.ОТГОНМӨНХ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ГХУССЗ-ИЙН 2018 ОНД
 ЗОХИОН ЯВУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018.01.04

Рашаант

Зорилго: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжүүд, иргэдийг татан оролцуулж тэдний оролцоог сайжруулах, тэдгээрт хууль зүйн мэдлэг мэдээллийг зохих шат дараалалтайгаар олгох, хууль эрхийг сурталчилж зөвөөр ойлгуулан таниулах, нийт иргэдэд түүнийг даган мөрдөхийг уриалан гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад оршино.

д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1	ГХУССЗ-ийн хурлаа хийж, 2018 оны ажлын төлөвлөгөөг гарган, ГХУССЗ-ийн даргаар батлуулах.	2018.01.04-ний өдөр	ГХУССЗ-ийн НБДарга	Ажил төлөвлөгдөнө.
2	"Монгол цэргийн баяр" арга хэмжээг зохион явуулах.	2018.03.16-18-ны өдөр хүртэл	Цагдаагийн хэсэг, Эрэгтэй чүүдийн зөвлөл	Иргэдийн цэрэг эх оронч сэтгэлгээ, цагдаагийн байгууллагад хандах эерэг хандлага нэмэгдэнэ.
3	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр "Архигүй, хүчирхийлэлгүй ирээдүйн төлөө" сэдэвт аян зохион явуулах	2018 оны эхний хагас жилд	Цагдаагийн хэсэг, ГХУССЗөвлөл	Архины хорт зуршлын талаар ойлголт авна, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлнэ.
4	Сум орон нутгийн хэмжээнд хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдийг үзлэгт бүрэн хамруулж, бүрэн бүтэн байдлыг хангуулан, бичиг баримтжуулах.	2-р улиралд	Цагдаагийн хэсэг, Татварын байцаагч	Сумын хэмжээнд хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдийн бүрэн байдал хангагдаж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлнэ
5	Алт, жонш, заг мод, үнэт чулуу гэх мэт байгалийн	Тухай бүр	Цагдаагийн хэсэг,	Байгал орчны журмын эсрэг

	баялгийг хууль бусаар олборлож, тээвэрлэж буй эсэхэд хяналт шалгалтыг холбогдох албан тушаалтнуудтай хамтран явуулж, таслан зогсоох, хуулийн дагуу арга хэмжээ тооцуулах.		Байгал орчны байцаагч, байгал хамгаалагч, БЗД нар	гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
6	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчлийг нэн даруй арилгуулах, хуулийн дагуу арга хэмжээ тооцох.	Тухайн үед нь	Цагдаагийн хэсэг	Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлнэ
7	Өсвөрийн цагдаа бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэн тэдэнтэй хамтран сургууль завсардсан хүүхдүүд болон сурагчид руу чиглэсэн үйл ажиллагааг явуулах	Жилдээ	Цагдаагийн хэсэг, Сургуулийн нийгмийн ажилтан	Хүүхдүүдтэй хамтарч ажиллах уялдаа холбоо сайжирч, ГХУССЗ-ийн ажил хүүхдэд хүрч чадна
8	Хууль бусаар согтууруулах ундаа болон тамхи худалдаалдаг асуудлыг холбогдох албан тушаалтнуудтай хамтран таслан зогсоох, дэрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа, цагийн хуваарьт хяналт тавих.	Тогтмол	Цагдаагийн хэсэг, ГХУССЗ	Аж ахуйн нэгж, байгууллагууд хуулийн дагуу ажиллаж хэвшинэ
9	Нийтээр тэмдэглэх баяр, ёслол /наадам, цагаан сар, шинэ жил, эх үрсийн баяр, цэргийн баяр, март-8/, урлаг, спортын тоглолт, бусад томоохон арга хэмжээний үеэр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр олон нийтийн эргүүл ажиллуулах.	Тухай бүр	Цагдаагийн хэсэг, ГХУССЗ-ийн гишүүд	Гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
10	Хулгайлах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд санамж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргэх, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий малчдын бүлэг нөхөрлөлийг шинээр байгуулж, бүлгийн ахлагч нарт явуулах үйл ажиллагааных нь талаар зааварчилга, мэдээллийг өгч, үнэмлэхжүүлэх.	Тогтмол	Цагдаагийн хэсэг	Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ.
11	Шинээр батлагдсан хууль, эрх зүйн актуудын талаар сургалт явуулах, иргэдэд мэдээлэл	Тухай бүр	Цагдаагийн хэсэг	Иргэдийн хуулийн мэдлэг нэмэгдэнэ.

	хүргэх.			
12	"Камержуулалт" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулах, камерын хяналтаа тогтмолжуулсан 1 ААН-ийг шагнаж урамшуулах, камерын хяналттай болоогүй ААН-үүдэд хуулийн дагуу арга хэмжээ авах.	2018 оны 1 дүгээр улиралд	Цагдаагийн хэсэг, ГХУССЗөвлөл	Гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
13	"Малчдын бүлгийг чадавхжуулах, малын им, тамганы мэдээллийн сан бүрдүүлэх" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	2018 оны 1 дүгээр улиралд	ГХУССЗ-ийн дарга, Хэсгийн төлөөлөгч, БЗД нар	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшлэнэ, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг сайжирна.
14	ГХУССЗ-ийн ажлын тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн гаргах	2018 оны 12 сард	ГХУССЗ-ийн НБДарга	Ажил тайлагнахад цэгцтэй болно.

ТӨЛӨВЛӨСӨН:
ХЭСГИЙН ТӨЛӨӨЛӨГЧ, ГХУССЗ-ИЙН НБ-ИЙН ДАРГА
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ Р.МӨНХБАТ